



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/288

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын Цагдаагийн газрын эрүүлжүүлэх ба саатуулах байрны ажлын зураг, төслийн зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100610

D:My Doc. Zahiramj. Zasag darga